# Аймгийн улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1964 оны төлөвлөгөөний тухай

## Аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргааны дарга депутат Ц.Жамсрангийн тавьсан илтгэлээс

(Үргэлжлэл)

нууд 3 дугаар сард багтаан худаг гаргах хэрэгтэй.

Аймгийн хэмжээгээр 1964 онд 3 тал саравчтай тэжээлийн ба тэжээх байр бүхий 243 хашаа барьж 67100 толгой малыг хашаажуулна.

Манай сангийн аж ахуй,хөдөө аж ахуйн нэгдэлд хашаа саравч барих ажлыг нийтийг хамарсан кампанит ажил болгож энэ оны 6 дугаар сарын 15—ны дотор дуусгахын хамт олонх сум нэгдлүүд 1,2 дугаар үеийн эрлийз төл хүлээн авахтай холбогдуулан төл хүлээн авах пүнзийг барих хэрэгтэй байна.

1964 онд малын өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаашид өргөтгөх болно.

Малын их, бага эмчийн 24 салбарт дээд. дунд мэргэжлийн 121 эмч ажиллана.

Малын цээж, боом, дуут хавдар, цэцэг, бразит, цагаан хорхой, хамуу зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 2205900 толгой малд тарилга хийж 1778600 малд лабортарын шинжилгээ хийнэ.

Цагаан хорхойн туулгыг өвөлжөөнд буух,гарах үеэр 6000 толгой малд хийнэ. Малын ороог идэвхжүүлэн хээл авалтыг сайжруулахын тулд хээлтэй гүүний сийвэнгээр 15000,био—тордогчоор 100 мянган малыг тарьж хээлийн шалгалтыг бүх үнээнд заавал хийх нь чухал.

1964 оны зун намрын улиралд малд тарга хүч авахуулах отрыг аймаг сумаас зориуд нарийн зохион байгуулалттай удирдах хэрэгтэй. Үхэр нэг бүрийг 280 кг амьдын жинд хүргэж таргалуулсан Заамар нэгдлийн үхэрчин Жамьяншарав, ямаа нэг бүрийг дунджаар 40 кг жинд хүргэж таргалуулсан Лүн сумын ямаачин Бэгз нарын жишээгээр малыг билчээрийн аргаар таргалуулах ажлыг сайжруулах хэрэгтэй.

Үхэр сүргийг онцлон өсгөх, ялангуяа үнээний сүүг нэмэгдүүлэх талаар сум, бригад бүхэн тодорхой ажил зохиох хэрэгтэй.

1964 оноос эхлэн нийт саальчдын дунд мянгатын хөдөлгөөнийг өрнүүлж депутатын танхимаар тэдний туршлагыг сурталчлан алдаршуулах, үнээнд хяналтын саалтыг сар тутам хийх,фермийн эрхлэгчийн семинар, саальчдын зөвлөлгөөнийг бүсчлэн хийлгэж туршлагыг солилцуулах ажил өргөн зохиох хэрэгтэй.

Сумын зоо—мал эмнэлгийн салбарууд,мал аж ахуйн мэргэжилтэн нар үнээний хээлтүүлгийг жилийн турш хийж сүүний их бүтээгдэхүүн гаргах журамд аажмаар шилжих хэрэгтэй байна.

Тэмээн сүргийн өсөлтийн тухай бид онцгой анхаарч тэмээг өсгөх түүний арчилгааны байдлыг эрс өөрчлөн сайжруулах хэрэгтэй.1964 онд газар тариалангийн талаар тавьж байгаа зорилт бол 1965 оны үрийн нөөцийг бий болгон үйлдвэрийг түүхий эдээр,хүн амыг хүнсний ногоогоор хангах, мал аж ахуйд тэжээлийн бааз бэлтгэхэд оршиж байна.

Сангийн аж ахуйнууд 90575 га, хөдөө аж ахуйн нэгдэл 21 мянган га-д тариалах болно.

Үүнээс үр тариа 101,4 мянган га,төмс 1175 га,хүнсний ногоо 570 га, малын тэжээлийн ургамлыг 8400 га-д хүргэнэ.

Газар тариалангийн хэмжээ, хурааж авах ургацыг үлэмжхэн нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Энэ онд үр тариа 95330 тонн, төмс 135100 тонн,хүнсний ногоо 9560 тонн,малын тэжээлийн ургамал 71475 тонныг хураан авч,үр тариа 67130 тонн,төмс 8300 тонн, хүнсний ногоо 8060 тонныг улсад тушаах болно.

МАХН-ын Төв Хорооны тогтоол ёсоор агротехникийн нарийн шаардлагаар үр тариа бусад ургамлын ургацыг нэмэгдүүлэх,юуны өмнө сангийн аж ахуй, нэгдлийн тариалангийн газрыг бүртгэж түүний ашиглалтыг сайжруулах нь чухал байна.

Тариалангийн газрыг салааны зохион байгуулалтаар эзэмших, техник засварыг 3 дугаар сарын 1-ний дотор багтааж хаврын хөрс боловсруулалтыг 100 хувь агрегатчилан явуулах нь манай сангийн аж ахуй,мал аж ахуйн машинт станцуудын хойшлуулшгүй зорилт болж байна.

Тариалангийн га дутмаас арвин их ургац хурааж байгаа тэргүүний сангийн аж ахуй, трактор комбайнчдын тоо олширсоор байгаагаас үзэхэд 1964 оны тариалалт,ургац хураах авах, тушаах төлөвлөгөөг давуулан биелүүлэх бололцоо бидэнд дүүрэн байна.

Аймгийн МААМС-уудыг зохион байгуулалт үйлдвэрлэлийн хувьд удирдах удирдлагыг сайжруулж техникийн ажилчдын мэргэжлийг дээшлүүлэн сахилга бат,хүмүүжил,ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд онц анхаарах ёстой.

Аж ахуйн гэрээгээр харилцан авсан үүргээ станц, нэгдлээс биелүүлэх хариуцлагыг эрс дээшлүүлэх нь чухал.

Төмс бол хүнсний ба малын тэжээлийн хамгийн чухал тарьмал юм. Төмсний ургацын төлөвлөгөөг жил дараалан таслаж байгаа дутагдлыг арилгаж, төмсний ургацыг нэмэгдүүлэх агротехникийн арга хэмжээг сайжруулах зорилт тавигдаж байна.

Газар тариалангийн боловсон хүчнийг бэлтгэх курсын чанарыг сайжруулах, нэгэнт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа боловсон хүчнүүдтэй уйгагүй ажиллаж тэдний ахуй амьдралыг дээшлүүлэн тогтвортой ажиллуулуулах хэрэгтэй.

### Аж үйлдвэрийн талаар.

Үйлдвэрийг хөгжүүлэх 1964 оны төлөвлөгөө бол урьдах оныхоос ихээхэн өвөрмөц агуулгатай тавигдаж байгаа бөгөөд ялангуяа хүнсний үйлдвэрийг олон талаар эрчимтэй хөгжүүлэхийг голлон анхаарч байгаа юм. Үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах,үйлдвэрлэлд дэвшилт техник,тэргүүн туршлагыг системтэй нэвтрүүлэх, нөөц баялгийг аль болохоор өргөн ашиглах замаар бүтээгдэхүүний хэмжээ,нэр төрлийг олшруулах нь чухлаар шаардагдаж байна.Аймгийн үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээг 1960 оны хөдөлбөргүй үнээр 6617,3 мянган төгрөгт хүргэнэ.

Үүний дотор хүнсний үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнийг 2342,3 мянган төгрөгт,цөцгийн тос үйлдвэрлэлтийг 79,8 тонн,талх нарийн боов архи дарсыг 2,9—27,8 хувиар өсгөх болно.Сум нэгдэл,аж ахуй бүр,талх нарийн боов,цагаан идээ боловсруулан ард түмний хэрэгцээг хангах зорилтыг дэвшүүлэн тавьж байна.

Аймгийн үйлдвэрлэлийн холбооны хэмжээгээр 4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.Үүнийг өнгөрсөн онтой харьцуулбал 1,8 хувиар өсч байна. Эдгээрээс гадна гэр ахуйн хэрэглэл,гутал,хувцасны засвар үйлчилгээний нэгдсэн тасаг байгуулах, аймгийн төвийн байгууллагуудын барилга засварын ажлыг дангаараа хариуцан гүйцэтгэх болно.

Аймгийн хэвлэлийн үйлдвэрлэлийн материаллаг бааз, хэвлэлийн хэмжээ жилээс жилд өсч орчин үеийн техникээр тоноглогдлоо. 1964 онд 86,8 мянган төгрөгийн бүтээгдэхүүн гаргах бөгөөд энэ нь өнгөрсөн оноос 47,8 хувиар өсөх юмаа. 1964 онд аймгийн цахилгаан станц 1255500 киловатт цагийн цахилгаан энерги үйлдвэрлэн гаргах бөгөөд үүний тулд станцын хүчийг 270 киловаттаар нэмэгдүүлж шугам сүлжээг тохижуулж дуусгахаар төлөвлөж байна. Их хайрханы уулын үйлдвэр 6383,8 мянган төгрөгний 180 мянган тонн вольфром гаргах болно.

1964 онд хөдөлмөрийн бүтээмжийг аймгийн хоршооллын үйлдвэрт 3,1 хувь,барилгат 1,5 хувь, хүнсний үйлдвэрт 7,2 хувиар нэмэгдүүлж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 11 орчим хувийг хөдөлмөрийн бүтээмжийн дээшлэлтээр хангах зорилт тавьж байна. Үйлдвэрийн бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулснаас барагцаалбал 364 мянган төгрөгний хэмнэлт гаргах болно.

### Худалдаа бэлтгэлийн талаар

1964 онд мал бэлтгэх төлөвлөгөөг, мал өсгөх улсын төлөвлөгөөтэй нягт холбон, малын хүч таргыг нэмэгдүүлж шахах нь улсын бэлтгэлд чанар сайтай цөөн мал тушааж олон толгой мал хэмнэн үлдээх зорилт тавих хэрэгтэй. Өнгөрсөн жилийн байдлаар Заамар, Баян сумдын бэлтгэлд нийлүүлсэн үхрийн дундаж жин 264—267 кг хүрч байхад Алтанбулаг сумын бэлтгэлд тушаасан үхэр дунджаар 221 кг, Сэргэлэнгийн хонь 47 кг татаж байхад Алтанбулаг Эрдэнийн хонь 29 кг, Бүрэн сумын ямааны дундаж 31 кг байхад Алтанбулаг, Мөнгөнморьт сумын ямаа 23—24 кг хүрч байсныг харьцуулан үзэж энэ жил тэргүүний сумдын тушаасан малын жинд хүргэх зорилтыг сум бүр тавих хэрэгтэй.Аймгийн дүнгээр 1474,0 тонн ноос,ноолуур,хөөвөр, хялгас бэлтгэнэ. Энэ нь хонь нэг бүрээс ноос 1420 грамм, тэмээнээс 5,3 кг, ямаанаас ноос 255 грамм,ноолуур 260 грамм, үхэр адууноос хөөвөр 305 грамм, сарлагаас 550 грамм хялгас,адууноос 410 грамм дэл,110 грамм сүүл, сарлагын хялгас 560 грамм,сүүл 50 грамм, монгол үхрээс сүүл 5 граммаас доошгүй хэмжээгээр авч хангах болно. Үүнд: гагцхүү цаг алдалгүй мал нэг бүрээс ашиглах ноосны гарцын хэмжээг нэмэгдүүлсэн тэргүүний сайчуудын туршлагыг эзэмших хэрэгтэй.

Мал бүхий иргэдээс мах, ноос сүү, улсад нийлүүлэх хуулийг шинэчлэн баталсан БНМАУ—ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигийг олон түмэнд сайн таниулах,ноогдлыг зөв хийж ойрын хугацаанд гардуулах хэрэгтэй. Нөгөө талаар ангийн үс, арьс шир, хөлдүү түүхий эд, ургамлын зүйлийг бэлтгэх төлөвлөгөө зарим талаар ихээхэн нэмэгдэв.Жишээлбэл малын яс 2 илүү дахин,тарваганы арьс 9 хувь,үнэг 2 дахин нэмэгдсэн жишээтэй байна.Хаягдал нөөц баялагийг дээд зэргээр ашиглах өндөр зорилт тавигдаж байна.

1964 онд түүхий эд бэлтгэх гол зарчим бол бололцоотой зүйлийг хугацаа хүлээхгүй урьдчилж биелүүлэх төмөр,ангийн үс хөлдүү ба ясны ихэнхийг эхний хагас жилд биелүүлэх үүргийг худалдааны байгууллагын ажилчдын өмнө тавих хэрэгтэй.

Худалдаа бэлтгэлийг удирдах газар дөрөвдүгээр сард болох аймгийн худалдааны агентийн зөвлөлгөөнийг угтаж ихээхэн ажил зохиох хэрэгтэй байна.

### Тээвэр холбооны талаар

Аймгийн хэмжээгээр 10,9 сая тонн км—ын үүрэг гүйцэтгэнэ.

Авто бааз 4,9 сая тонн км, тээвэр 4,47 сая хүн км—ийн үүргийг гүйцэтгэнэ.

Чиргүүлийг дээд хэмжээгээр ашиглаж машин сул зогсолтыг багасгаж,даацыг дүүрэн ашиглах хэрэгтэй байна.1964 онд аймгийн харилцаа холбоо телефон шугам Мөнгөнморьт суманд, радио станц 1—ийг Баян суманд, шуудан салбар 4—ийг Алтанбулаг, Заамар, Баянзүрх, Мөнгөнморьт сумдад шинээр байгуулах, телефон цэгийн тоог 140, шуудан хайрцаг 5, радио цэг 680—ыг нэмж ажиллуулах болно.

Харилцаа холбооны өмнө үйлчилгээг эрс сайжруулж,байгуулсан техник төхөөрөмжийн эзэмшилт ашиглалтыг дээшлүүлэн ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх зорилтыг тавьж байна.

### Их барилгын талаар

Аймгийн барилга контор 618,3 мянган төгрөгийн материалыг үйлдвэрлэн гаргаж нийтдээ 3,8 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх болно.

1964 онд ашиглалтанд оруулах барилга аймгийн төвийн арван жилийн дунд сургуулийн дотуур байр, Архустын техник засварын газар, Алтанбулагийн зохиомол хээлтүүлгийн станц, Жанчивлангийн рашаан эмнэлгийн барилга зэрэг томоохон барилгууд орно.

Гэвч хэрэгцээний шаардлагаас энэ онд зөвхөн эхлэж 1965 онд дуусах ёстой барилгуудыг урьдчилан барьж гүйцэтгэх зорилго тавих хэрэгтэй.

Энэ зорилтыг биелүүлэхийн тулд:

Барилга барих үндсэний мэргэжилтнийг яаравчлан бэлтгэх энэ талаар бидэнд бэрхшээл их байгаа боловч давах, материалын бэлтгэлийг 4 дүгээр сарын 1 ний өмнө бүрэн хангах, барилга угсралтын графикийг хатуу мөрдөх, хөдөлмөр зохион байгуулалт, техник механизмын ашиглалтыг эрс сайжруулах, хөдөлмөр хөнгөвчлөх механикжуулах шийдвэртэй алхам хийх нь шаардагдаж байна.

(Төгсгөл нь 4 дүгээр нүүрт)

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО, А Д. Х. Г. ЗАХИРГААНЫ СОНИН

16 дахь жилд
№ 15 (1350)

1964 оны
2 дугаар сарын 20

ПҮРЭВ

## Аймгийн намын бүгд хурлын шийдвэрийг амжилттай биелүүлье

Аймгийн намын III бүгд хурал, хоёрдугаар сарын 10, 11-ний өдрүүдэд хуралдаж МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын дүн ба аймгийн намын байгууллагуудын зорилтын тухай аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Б. Дэжидийн тавьсан илтгэлийг хэлэлцэж чухал шийдвэр гаргалаа.

Аймгийн намын бүгд хуралд бүгд хурлын гишүүдээс гадна сум хороод, албан үйлдвэрийн газрын намын үүр, хороодын нарийн бичгийн дарга, АДХ—ын Гүйцэтгэх захиргаадын дарга, бүх сумдын тасаг, бригадын дарга нар оролцож санал зөвлөлгөөнөө тодорхой солилцов.

Аймгийн намын бүгд хурал МАХН—ын Төв Хорооны V бүгд хурлын шийдвэрийг санал нэгтэй сайшааж, Намын Төв Хорооны энэ шийдвэр нь тус аймгийн хөдөлмөрчдийг бүтээлч хөдөлмөрт улам зоригжуулж байгааг илэрхийлэн тэмдэглэв.

БНМАУ социалист орнуудтай хамтран ажиллах ЭЗХТЗ—ийн гишүүн болсон явдал тус улсын түүхэн хөгжилд үнэлж баршгүй ач холбогдолтой зүйл бөгөөд манай оронд барилга байгуулалтын ажлыг нийт ард түмний хэрэг болгож явуулах болсон нь цаг үеэ олсон дайчин шийдвэр байв.

Бүгд хурал аймгийн улс ардын аж ахуй, соёлын бүх салбарт манай нам, улс, олон нийтийн байгууллага, бүх хөдөлмөрчдөөс олсон ололтыг дүгнэж мөн ажлын салбарт илэрч байгаа хоцрогдол, тасалдал, ажлын хариуцлага, сахилга батгүй явдал, салан задгай, аж ахуйч биш ажиллагааг илрүүлэн шүүмжлэв.

Гуравдугаар бүгд хурал, барилга байгуулалтын ажлыг сайжруулах тодорхой заалт гаргаж 1963 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг биелүүлэхэд олсон амжилтаа улам бататган бэхжүүлэхэд нэгдэл, САА—н үйлдвэрлэлийн бригад, тасгийн роль өндөр болсныг дэвшүүлэн тавилаа.

Аймгийн намын бүгд хурал 1964 онд 2 оны барилга байгууллалтын программыг шийдвэрлэсэн байх зорилтыг барилгачдын өмнө тавьж, барилга нэг бүрийн эхлэх, дуусах графикийг баталлаа.

Үүнийг биелүүлэхийн тулд барилгын материал, ажиллах хүчийг 3 дугаар сарын дотор бүрэн бэлтгэх, ажилчин албан хаагчдыг барилгын мэргэжилд сургах ажил хүчтэй зохиох, барилгын ажилд оролцох нийт хөдөлмөрчдийн хөдөлгөөнийг өрнүүлэх, барилгын хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, бүтээмжийг өндөржүүлэх, барилга үйлдвэрлэлийг механикжуулах, машин механизмын хүч чадлыг дүүрэн ашиглах, барилгын өртгийг хямдруулах талаар чухалчлан ажиллахыг заагаад аймгийн намын хороонд барилгын орон тооны бус хэлтэс, барилга конторт сан техникийн тасаг, нэгдлүүдэд барилгын байнгын бригад байгуулах, аймгийн барилгачдын 2 дугаар зөвлөлгөөнийг хийлгэх зэрэг зохион байгуулалтын чухал арга хэмжээ авав.

Аймгийн 1964 оны төлөвлөгөөт зорилтуудыг хангаж, хүн амыг соёлжуулахад суурь, бригад, тасаг, ферм, түүний дэргэдэх намын хэсэг, худалдааны агентын ажлыг эрс сайжруулахыг нам, улс, хоршоолол, худалдааны байгууллагад бүгд хурлаас үүрэг болгоод эдгээр газруудад аргачилсан удирдлага, намын үзэл суртал, зохион байгуулалтын ажлыг төвлөрүүлж үйлдвэрлэлийн гүнд ажиллах асуудлыг онцлон тавьж, үйлдвэрлэлийн даалгавар биелэлтээр аймаг, сумандаа тэргүүн бригад, суурь, тасаг, ферм болох хөдөлгөөнийг өрнүүлэхээр тогтоов.

Суурьудад зохиогдох хүмүүжлийн ажлыг эрс сайжруулах, намын ухуулгыг үйлдвэрлэлийн даалгавар биелүүлэхэд чиглүүлэх, худалдааны агентын үйлчилгээг дээшлүүлж тэдний ажиллах нөхцөлийг хангах, бүх агентын зөвлөлгөөнийг 4 дүгээр сард аймгийн төвд хийлгэж туршлага солилцуулах нь зүйтэй гэж үзэв.

Аймгийн намын бүгд хурлаас социалист уралдааны эрч хүчийг улам чангалж сумдын уралдааныг бүсчилж зохиох, улирал тутам шалган дүгнэж байх, сумуудын нам, улсын байгууллагаас графикийг удирдлага болгох, биеэ дааж ажиллах бололцоог хангах, аж ахуй соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд олон нийтийн байгууллагаас гүйцэтгэх үүргийг өндөржүүлэн ажиллахыг үүрэг болголоо.

Бүгд хурлын заалтыг биелүүлэх зорилт намын бүх байгууллагын өмнө тулгаран зогсож байна. Бүгд хурлын шийдвэрийг хүн бүрт хүрэлцүүлэн сурталчилж идэвх хөдөлгөөнийг өрнүүлэх, тогтоолын заалт бүрийг зохион байгуулж, ажил болгох ёстой.

Үүний тулд ээлжит зорилт бүрийг цаг үед нь хийх, бүх байгууллагын ажлыг жигд урагшлуулах, хүн бүр эрхлэн хариуцсан ажлаа хангасан байхад оршино.

Юуны урьд цаг агаарын тохиромжгүй нөхцлөөс аврах, төл бойжуулах ажилд бүх нийтийн анхаарлыг төвлөрүүлэх, хаврын тариалалтын бэлтгэлийг сангийн аж ахуй, МААМС, нэгдэл бүр яаравчлан хангах, барилгын ажлыг шуурхайлж, хөлдүү түүхий эдийн бэлтгэлийг түргэтгэх хэрэгтэй байна. Аймгийн намын бүгд хурлын шийдвэр аж ахуй, соёлын зорилтыг жигд хурдтайгаар биелүүлэхийн үндсэн нөхцөл бол хүн нэг бүрийн ажлын хариуцлалага нам, улсын сахилга бат өндөрт байж, хувьсгалт хуулийг ёсчлон биелүүлэх, гүйцэтгэлийн шалгалтыг ажил бүхэнд нэвтрүүлэх явдал мөн.

Аймгийн намын бүгд хурлын шийдвэрийг биелүүлэхийн тулд намын үүр хороодын дотоод ажлыг эрс сайжруулан аж ахуйг удирдах явдалтай намын зохион байгуулалт үзэл суртлын ажлыг улам нягт хослож, намын байгууллагын удирдан чиглүүлэх роль, намын хяналтыг өндөрт тавьж ажиллах хэрэгтэй.

Аймгийн намын бүгд хурал, АДХ—ын чуулганаар батлагдсан 1964 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөө, тэргүүн туршлага, графикийг ажлын үндсэн удирдамж болгон ажиллах нь чухлаар шаардагдаж байна.

Аймгийн намын бүгд хурлын шийдвэрийг амжилттай биелүүлэхийн төлөө 1963 оныхоо туршлага дээр суурилж хүн бүр чармайлт гарган намын гишүүн бүр үлгэрлэн манлайлах ёстой.

## РАПОРТ

**Аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Б.Дэжид, АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дарга Ц. Жамсран, Худалдаа бэлтгэлийг удирдах газрын дарга Д.Гончиг нар танаа**

Баянцагаан сумын хөдөлмөрчид, сумын 1964 оны төлөвлөгөөт зээрийн мах, туулай, зэс, гууль, техникийн тосны жилийн төлөвлөгөөг 100—103 хувиар биелүүлснийгээ баяртайгаар илэрхийлье.

Баянцагаан сумын намын үүрийн нарийн бичгийн дарга *Бадам-Очир*

Сумын АДХ—ын Гүйцэтгэх Захиргааны дарга *Сүхбаатар*

Худалдаа бэлтгэлийн ангийн дарга *Сосорбарам*

## ЗУДТАЙ ТЭМЦЭЖ БАЙНА

ЭРДЭНЭ—УУЛ. Архуст сумын нутагт 25—30 см цастай, өдөртөө 30—37 градус, шөнөдөө 39—42 градус хүйтэрч байна.

Архуст сум-сангийн аж ахуйн захиргаа намын хороо, сумын төвөөс 48 хүн, 5 машинтай 2 бригад болж зудын байдалтай байгаа 2,3 дугаар фермийн малчдад тусалж зарим суурийг нүүлгэж өвөлжөө бууц засах ажлыг хийж байна. Одоо сумын хэмжээгээр 300 гаруй малын хорогдолтой байна. Энэ сумынхан зуд эсэргүүцэх талаар бүх нийтээрээ тэмцэж байна.

ЭНГЭР—ШАНД. Баянзүрх сумын нутагт 15-20, зарим газар 35-40 см зузаан цас унаж хүйтний эрч улам нэмэгдсэн байна.

Сумын захиргаа намын үүр, зудын хүнд байдалтай байгаа үржил хонины бригадад 3 машин, 15 хүнтэй нэг бригад гаргаж малчдад өвс татах, хэвтэр бууц дулаалах, зарим суурийг нүүлгэх зэрэг ажил хийж байна.

Баянзүрх сумын хэмжээгээр малын үхэл хорогдолгүй, 2000 мал төллөж төл нь бүрэн бойжиж байна.

## Аймгийн улс, ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1964 оны төлөвлөгөөний тухай

### Аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дарга, депутат Ц. Жамсрангийн тавьсан илтгэлээс

Депутат нөхөд өө!

МАХН—ын 14 дүгээр их хурлаар баталсан 3 дугаар таван жилийн төлөвлөгөөний 3 дахь жилийн төлөвлөгөөг манай орны бүтээлч хөдөлмөрчид амжилттай биелүүлээд 4 дэх жилийн төлөвлөгөөт ажилд шилжлээ.

Тус аймгийн нам, улс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчид, МАХН—ын Төв Хорооны V бүгд хурлын шийдвэр, БНМАУ-ын Ардын Их Хурлын II чуулганаар батлагдсан улс, ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1964 оны төлөвлөгөөг давуулан биелүүлэх өрнүүн хөдөлмөрийнхөө эхний улирлын ажиллагаанд зориг төгөлдөр орж байна.

Манай орны яруу алдарт хөдөлмөрчид эх орондоо социализмын материал техникийн бааз байгуулах их үйлстээ урьд онуудаас улам гарамгай сайхан амжилт олж 1963 онд улсын хэмжээгээр малаа 1,4 сая толгойгоор нэмэгдүүлж төрөл бүрийн ноосны төлөвлөгөөг бараг 1000 тонноор давуулан биелүүлж, үйлдвэр, газар тариалан, ард түмний материаллаг аж байдал, соёлын талаар үлэмж ахиц гаргасныг сайшаан тэмдэглэлээ.

БНМАУ—ын Ардын Их Хурлын чуулган, 1964 оны улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөний талаар дайчин том зорилт дэвшүүлэн тавихдаа тус улсын малыг 6 хувиар өсгөх, газар тариаланг 707,8 га—д хүр-

(Үргэлжлэл нь 2 дугаар нүүрт)

